

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023
оны 12. дугаар сарын 27.-ны өдрийн 4/401
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

4/401

Байгууллагын нэр:

Экологийн цагдаагийн алба

Албан тушаалын нэр:

Дүн шинжилгээ, үнэлгээ
хариуцсан чиглэлийн ахлах
байцаагч

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс

Албан тушаалын ангиал, зэрэглэл:

ТТ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүрэг, 7 дүгээр хороо,
Эрхүүгийн гудамж-6

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй
байдал үүссэн, террорист халдлага, онц
болон дайны байдал зарласан, онц ноцтой
гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй
тохиолдолд уртасгасан цагаар болон
өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын хууль тогтоомж, удирдлагын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион
байгуулах, биелэлт үр дүнг тооцох, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн
мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, цаашдын төлөв
байдлыг тодорхойлох, эрх бүхий нэгж, албан тушаалтыг мэдээллээр хангахад оршино.

Албан тушаалын зорилт:

1. Экологийн цагдаагийн албаны үйл ажиллагаанд хамаарах хэрэгжилтийг хангах, хяналт-
шинжилгээ үнэлгээ хийх бодлогын баримт бичиг, Цагдаагийн байгууллагын үйл

ажиллагааны журмын хэрэгжилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

2. Албаны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн хүрсэн түвшин, ажлын үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, алба хаагчдын хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3. Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн хүрээнд холбогдох асуудлаар мэдээлэл боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах;

4.Харьяалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дунд тулгуурлан албаны даргын гаргах шийдвэр, бодлогын хувилбар, үйл ажиллагааны санал, зөвлөмж боловсруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

5.Зохион байгуулалтын нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх. Алба хаагчдын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

6.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Байгууллагын үндсэн зорилго, зорилтын хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд бодит байдалтай биечлэн танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>1.2.Байгууллагын үйл ажиллагааны үр дунд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ гүйцэтгэлийн бодит үр дунг төлөвлөсөн зорилттой харьцуулж, өсөлт бууралтыг тооцоолох аргаар хийж, зорилт, төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүүгийн шалтгааныг илрүүлэх, тасалдлыг нөхөх, илүү өндөр түвшнийг дараагийн зорилго, зорилт болгон дэвшиүүлэх боломж нөхцөл байдлыг судалж, үр дүнгийн үнэлгээг гаргах ажлыг зохион байгуулах;</p> <p>1.3.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 133/ "Тэргүүний алба хаагч, байгууллага шалгаруулах" ажлыг зохион байгуулж, үр дүнг албаны даргын өмнө хариуцна.</p>	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн үндэслэл оновчтой болж, байгууллагын үйл ажиллагааг зөвлөмжээр дэмжих нөхцөл бүрдэнэ	Г Г,Х Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Албаны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн хүрсэн түвшин, ажлын үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>2.2.Албаны зохион байгуулалтын нэгж, экологийн асуудал хариуцсан алба хаагчдын хийж хэрэгжүүлсэн</p>	Нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдана.	Г Г

	ажил, арга хэмжээ “Ажил дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх.		
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1 Албаны хэмжээнд хийж хэрэгжүүлсэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой танилцуулга, тайлан, бусад холбогдох мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт бүхий танилцуулга, мэдээлэл бэлтгэж эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах.</p> <p>3.2 Албаны хэмжээнд дагаж мөрдөх тушаал шийдвэрийн биелэлт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлгээний тайлан, дүгнэлтэд үндэслэн санал, зөвлөмж боловсруулан холбогдох нэгж, албан тушаалтанд хургуулж, удирдлагад бодлогын дэмжлэг үзүүлэх.</p>	Мэдээллийн үнэн бодит байдал хангагдаж, нэгдсэн мэдээллээр хангагдах нөхцөл бүрдэнэ.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1.Статистик мэдээнд тулгуурлан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, хэргийн шийдвэрлэлтийн талаар мэдээлэл, танилцуулга бэлтгэн нэгжийн удирдлага, алба хаагчдыг мэдээллээр хангах;</p> <p>4.2 Харьяаллах гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж шалтгаан, нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлс, чиг хандлагыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх ажлын талаар санал, зөвлөмж, ажлын чиглэл боловсруулах, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх.</p>	Гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хэрэгжилтийг хангах мэдлэг, мэдээлэл, бодит өгөгдөл дүн шинжилгээнд суурилсан үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ. Удирдах албан тушаалтны шийдвэрийн үндэслэл оновчтой болж байгууллагын үйл ажиллагааг зөвлөмжөөр дэмжих нөхцөл бүрдсэн байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	<p>5.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн, санал, зөвлөмж боловсруулж, зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлэн, хяналт тавьж, үр дүнг тооцож, удирдлагыг мэдээллээр хангах;</p> <p>5.2.Алба хаагчдад ажлын үүрэг чиглэл өгч, мэргэжлийн удирдлагаар ханган, үйл ажиллагааг хариуцан зохион байгуулна;</p> <p>5.3 Дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан байцаагч нарт судалгаа, дүн</p>	Хяналт шинжилгээгээр зөрчил дутагдлыг тогтоосноор цаашид албаны үйл ажиллагаа хэвийн явагдаж, алба хаагчдын хариуцлага сайжирна.	Г Г.Х Г.Х

	шинжилгээ хийх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх. 5.4 Удирдлагын шийдвэрээр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах /код 112/ журам"-ын 112.7-д заасан албаны шалгалт явуулах.		Г.Х
6 дугаар зорилтын хүрээнд	6.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж байгууллагын ажилтнууд болон харилцагч үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх; 6.2. Авлига хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 6.3. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	Цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүрэг, хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүргийн биелэлт хангагдана.	Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Эрх зүй /0421/		
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан, үүнээс харьяа нэгжийн болон албаны ахлах түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах; -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх.	
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж шийдлийн хувилбарын талаар зөвлөх.	
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх.	
	Манлайлах	-Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.	
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, Монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх;	

-Компьютерын Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх;
-Нууц хадгалах.

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Дэд бөгөөд Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга

**Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:**

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;
Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

**Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:**

Албан тушаал:
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

**Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:**

Байгууллагын нэр:
Шийдвэрийн огноо:
Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2022. 12. 27

Дугаар: A/401

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны дугаар сарын-ны өдөр

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:

.....
.....

2023 оны дугаар сарын-ны өдөр